БАТЛАВ.

ЗАСАГ ДАРГА ..... Л.ТӨМӨРЧӨДӨР

ЗУУНМОД СУМЫН 1-Р БАГ, НИЙГМИЙН ДААТГАЛ, 18-Р БАЙРНЫ ОРЧИМД ГАЗАР ЧӨЛӨӨЛЖ, ТОХИЖИЛТ, АВТО ЗАМ ЗАСВАРЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Дугаар: 02/25

2025.01.22 Зуунмод сум

Зураг төсөл боловсруулах үндэслэл	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит бус "Нэгдүгээр хуралдааны 17 дугаар тогтоолоор 2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Нийгмийн даатгал, 18-р байрны орчимд газар чөлөөлж, тохижилтын ажлыг хийхээр хөрөнгө батлагдсан.
Байршил, инженерийн шугам сүлжээний одоогийн байдал	Зуунмод сумын 1-р баг Нийгмийн даатгал, 18-р байр орчмын тохижилт хийх талбайд 18-р байрны а, б блокийн 2 орон сууц, авто машины 20 граж, Поркурорын газар, хашаатай 4 айл, Нийгмийн даатгал, 1 төмөр хашаа, Чансаа зоогийн газар байрлаж байна. Авто зам 144 м, явган зам, гэрэлтүүлэгтэй. Дулаан хангамж, цэвэр усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээтэй.
Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ	Зуунмод сумын 1-р баг Нийгмийн даатгал, 18-р байр орчмын суурьшлын бүсийг хамруулан 0.8 га талбайд төлөвлөнө.
Зураг төсөл боловсруулах ажлын үе шат	Эх загвар зураг /Төлөвлөлтийн эхний хувилбар боловсруулан захиалагчид танилцуулан захиалагчтай зөвшилцөн батлуулна./ Ажлын зураг төсөл боловсруулах - Авто зам засварын ажлын зураг - Явган зам, талбай, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, спорт, тоглоомын талбайн тохижилтын ажлын зураг/ - Ажлын төсөв
Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Монгол Улсын хуулиуд:</u> - Хот байгуулалтын тухай хууль - Барилгын тухай хууль - Авто замын тухай хууль - Геодези зураг зүйн тухай хууль <u>Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд:</u> - Зуунмод хотын сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө <u>Норм норматив, стандарт:</u> - "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016 - "Хот суурины гудамж зам төлөвлөлт" БНбД 32-01-04 - "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" АЗУАГН 2.01.01-2004 - "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл БНбД 11-07-04-ийн 11 хэсэг инженер геодезийн ажил

	- *"Геодезийн ажил БНбД 3.01.03-88* - *"Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS4597:2014* - *"Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009* - *Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598: 2020* - *"Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНбД 30-01-04* - *Явган хүний зам, талбайн төлөвлөлт. техникийн шаардлага MNS 6808: 2019* - *"Зам замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох заавар" ЗЗБНбД81-013—2019* - *"Авто замын барилгын ажлын төсвийн жишиг норм" БНбД 81-25-07* - *Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам"*
Баримт бичгийн бүрдэл	*<u>Сүүрь судалгаа:</u>* - *Байр зүйн зураглал, геодези, хэмжилтийн ажлын тайлан* - *Техникийн шаардлага* - *Техникийн нөхцлүүд* - *Граж, айл өрх, албайн байгууллагын судалгаа хийж, тохижилтын ажлын хүрээнд газар чөлөөлөлт хийх ажлын зураглал, судалгаа* *<u>Ажлын зураг:</u>* - *Өндөржилт, инженерийн бэлтгэл арга хэмжээний ажлын зураг* - *Инженерийн шугам сүлжээний давхцал хэсэгт авах арга хэмжээ* - *Авто зам, явган замын ажлын зураг төсөл* - *Тайлбар бичиг* - *Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж, спорт талбай, ахмадын амрах талбай, хүүхдийн тоглоомын талбайн ажлын зураг* - *Гэрэлтүүлгийн ажлын зураг* - *Инженерийн шугам сүлжээний нэгдсэн төлөвлөлт* *<u>3 хэмжээст зураглал, анимэйшн:</u>* - *Зам, талбайн төлөвлөлт зураглал* - *Хөдөлгөөнт анимэйшн видео* *<u>Ажлын төсөв</u>* - *Төсөв /эстиматор про программаар хийсэн байх ба үүнээс тоо хэмжээг тусад нь гарган хавсаргана. /2 хувь/* *<u>Магадлалын дүгнэлт, эх хувь болон хуулбар хувь 2%</u>* - *Ажлын зураг, төсөв, геологийн дүгнэлт, бусад материалыг 2 хувь захиалагчид хүлээлгэн өгнө. / эх хувь1ш, хуулбар1ш* - *Тоон байдлаар DVD-нд хуулбарлан ирүүлнэ. /Төлөвлөлтийн зураглалыг Auto CAD-аар, 3 хэмжээст*

	зургийг тусгай программ/Sketch up, Lumion, 3d MAX/-аар бусад зургууд болон төсвийг PDF хэлбэрээр иргүүлнэ./
Шийдвэрлэх үндсэн асуудлууд	*Нийт 8000м2 талбайд тохижилтын ажлын зураг төсөлд боловсруулах бөгөөд 20 гражийн барилгыг буулган чөлөөлж, бага, дунд, ахмад настнуудын тоглоом, спорт талбай төлөвлөнө. 18-р байр, Нийгмийн даатгал, Чансаа зоогийн газрын авто машины зам, зогсоол, гарц орцыг төлөвлөнө.* - *Одоо байгаа 144м авто замын засварлах, авто зогсоол шинэчилэн төлөвлөх* - *Авто замын 2 талд явган замыг шинэчлэн байгуулна.* - *18-р байрны орчмын ахмад, дунд, бага насны тоглоом, спорт талбай төлөвлөх* - *Авто замын өөрийн ус зайлуулах суваг төлөвлөх.* - *Хорооллын гэрэлтүүлгийг шинэчилэн төлөвлөх* - *Авто замын тэмдэг тэмдэглэгээ стандартын дагуу төлөвлөнө.*
Эдийн засгийн тооцоо, төсөв	*Авто замын засвар, тохижилтын ажлыг эстиматор про программаар авто замын үнэлгээ, барилгын ажлын үнэлгээгээр ангилж хийнэ.*
Төслийн онцгой нөхцөл	- *Гудамж төслийн хүрээнд хийгдсэн авто замын зураг төслийн төлөвлөлттэй уялдуулах* - *Байрны зогсоол, Поркуроын газрын гарц орцыг тусдаа болгон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан стандар зогсоол төлөвлөх* - *Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах ба зураг төслийг боловсруулахдаа холбогдох байгууллагуудтай зөвшилцсөн байх.* - *Авто зам, уулзвар болон авто зогсоолын ус зайлуулах байгууламжийг цогц байдлаар шийдвэрлэх, замын дагуух гадаргуун ус зайлуулах байгууламжийг орчноор нь тооцож шийдвэрлэх,* - *Инженерийн байгууламжтай холбоотой шилжүүлэх, буулгах зардлуудыг тусгуулах.*
Зураг төсөл боловсруулах хугацаа	*Гэрээ байгуулснаас хойш 3 сарын хугацаатай гүйцэтгэх ба магадлалаар хянуулах хугацаа орсон.*
Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	*Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт*
Захиалагч байгууллага	*Төв аймгийн Засаг даргын ЗДТГ, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар*
Гүйцэтгэгч байгууллага	*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулна.* *Авто замын зураг төсөл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах эрх бүхий аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.*
Зөвшөөрөлцөх байгууллага	*Захиалагч болох Төв аймгийн ЗДТГ, ГХБХБГ, аймгийн ерөнхий архитектор, холбогдох байгууллагатай зөвшөөрөлцөх;*

	Төлөвлөгөөний баримт бичгит магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах;

ЗУУНМОД СУМЫН 1-Р БАГ, НИЙГМИЙН ДААТГАЛ, 18-Р БАЙРНЫ ОРЧИМД ГАЗАР ЧӨЛӨӨЛЖ, ТОХИЖИЛТ, АВТО ЗАМ ЗАСВАРЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Зөвшөөрсөн:

Хөгжлийн бодлого төлөвлөлт, Хөрөнгө оруулалтын

хэлтсийн дарга *Д.Саран-Эрдэнэ*

Хянасан:

Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын

газрын дарга *Б.Насанжаргал*

Боловсруулсан:

Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга, аймгийн ерөнхий архитектор:

Д.Алтансүх

Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлал хариуцсан мэргэжилтэн:

Б.Бат-Оргил